

Хvний хөхөнцөр вирусийн эсрэг вакцин

Хавдартай тэмцэх vндэсний хотолбор, Дархлаажуулатын vндэсний хотолборийн хvрээнд Монголын мянганы сорилтын сангийн санаачлага, санхvвгийн дэмжлэгтэйгээр “Хvний хохонцор вирvс”-ийн халдвараас сэргийлэх вакциныг дархлаажуулалтанд шинээр нэвтрvлэхээр бэлтгэж байна.

2005 онд Улаанбаатар хотын оршин суугч 15-59 насны нийт 969 эмэгтэйчvвдэд ХХВ-ын тархалтын судалгаа ДНК-ийн шинилгээгээр хийхэд 35% буюу 350-д нь, 25-аас доош насанд 48.5% нь уг вирvс илэрсэн. Мон эдгээр хvмvвсийн цусны ийлдсэнд хийсэн эсрэг бие илрvлэх шинжилгээгээр 38%-д нь эерэг (+)буюу ХХВ-ээр халдварлагдаж байсан байна. Эдгээр vзvлэлт нь Азийн орнуудад адил аргаар хийсэн судалгаа шинжилгээнvвдтэй харьцуулахад хамгийн ондор байна.

Манай улсад сvвлийн жилvвдэд умайн хvзvвний хорт хавдар эмэгтэйчvвдэд тохиолддог хорт хавдрын дотор 2 дугаарт, нас баралтын 4 дvгээрт орж байна. Умайн хvзvвний хорт хавдрын шинэ тохиолдол 2006-2008онуудад 10.000 хvн амд 1.23-1.55 промилль болж цаашид осох хандлагатай байна.

Иймээс дэлхийн 100гаруй улс оронд хэрэглэгдэж, vр дvнтэй болох нь тогтоогдсон, НҮБ-ын агентлагууд зовшоорсон, ДЭМБ-ын стандартыг хангасан “Хvний хохонцор вирvс”-ийн халдвараас сэргийлэх вакциныг **дархлаажуулалтанд ve шаттайгаар нэвтрvлэх бодлого хэрэгжvлж байна.**

□□ Умайн хvзvвний хорт хавдрын өвчлөлийн байдлыг харгалзан эхний ээлжинд Сэлэнгэ, Өмнөговь аймаг, нийслэлийн Баянгол, Багануур□ дvвргийн 11-15 насны, 14491 охидыг сонгон дархлаажуулахаар бэлтгэж байна. Цаашид дээрх насны бvх охидыг бvрэн хамруулан дархлаажуулах зорилготой байгаа.

□□ Одоо хэрэглэхээр сонгож аваад байгаа GARDASILвакцин нь Хvний хохонцор вирvсийн хамгийн тvгээмэл тохиолддог 6,11,16,18 дах хэвшинжээр vвсгэгдсэн умайн хvзvв, vтрээ, гадна бэлэг эрхтэн, хошногоны хорт хавдар, бэлгийн vв болон

эдгээр

хавдарын урьтал овчнvдээс 70-90% сэргийлнэ.

Дархлаажуулалтын эхний тунг 2012 оны 3 дугаар сарын 12-16 нд, 2 дахь тунг 2012 оны 5 дугаар сарын 20-25 нд, 3 дахь тунг 2012 оны 9 дvгээр сарын 10-14 нд тус тус хийнэ. Энэ вакцин нь булчинд тарьж хэрэглэдэг вакцин байгаа.

Сонгогдсон аймгуудын ЭМГ-тай хамтран бэлтгэл ажлуудаа амжуулж, товлосон хугацаанд дархлаажуулалтаа хийхээр ММСС, ХОСvТ идэвхтэй ажиллаж байна.

Шинэ вакцин нэвтрvлэх ажлыг санаачлан, санхvвгийн дэмжлэг vзvвлж хамтран ажиллаж байгаа мянганы сорилтын сангийнхан, хvн амд зов тодорхой мэдээлэл хvргэхэд хамтран ажиллаж байгаа хэвлэл мэдээллийнхэнд талархал илэрхийлье.

ХОСvТ-ийн эрт сэрэмжлvлэх хариу арга хэмжээний нэгж